



САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 оны 10 дугаар сар)

Яамны газруудын 2024 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны биелэлтийг “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан дараах 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд үнэлгээний дундаж 98.7 хувьтай байлаа.



99.3%
Сарын
төлөвлөгөө
24.8 оноо



97.6%
Албан бичгийн
шийдвэрлэлт
9.8 оноо



100.0%
Шуурхай үүрэг
даалгавар
5.0 оноо




96.6%
Ажлын цаг
ашиглалт
9.7 оноо



100.0%
Үйл ажиллагааны
ил тод нээлттэй байдал
10.0 оноо

Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ /2024.10/

№	Газар	Сарын төлөв- лөгөө	Албан бичгийн шийд- вэрлэлт	Ш/ү даалгав- рын хэрэгжилт	Цаг ашиглалт	Ү/а-ны ил тод нээлттэй байдал	Нийт		Хувь
		Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Нийт авах	Авсан оноо	
1	ТБТГ	25.0	9.2	5.0	9.4	10.0	60.0	58.6	97.7
2	ТаБГ	25.0	9.7	5.0	10.0	10.0	60.0	59.7	99.5
3	НБББГ	25.0	10.0	-	9.9	10.0	55.0	54.9	99.8
4	СБГ	23.3	9.7	-	10.0	10.0	55.0	53.0	96.4
5	ХСХОГ	25.0	9.9	-	9.7	10.0	55.0	54.6	99.3
6	СТСГ	25.0	10.0	-	9.7	10.0	55.0	54.7	99.5
7	ТЗУГ	25.0	9.3	5.0	9.6	10.0	60.0	58.9	98.2
8	ТСГ	25.0	9.9	-	9.1	10.0	55.0	54.0	98.2
9	СХЭУГ	25.0	10.0	-	9.7	10.0	55.0	54.7	99.5
10	ХЭЗГ	25.0	10.0	-	9.6	10.0	55.0	54.6	99.3
Нийт дундаж							575	557.7	98.7



/Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/

Сангийн яамны Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/116 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу яамны газруудын 2024 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, үр дүнг үнэлэхэд дунджаар **98.7 хувьтай** байлаа.

2024 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр НБББГ 99.8, ТаБГ 99.5, СТСГ 99.5, СХЭУГ 99.5 хувиар тэргүүлж байна.



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (10 сар)

99.3
хувь

№	Газар	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт							Биелэлтийн хувь	Авсан оноо
			100	90	70	50	30	0	Үнэлэх боломжгүй		
1	ТБТГ	14	14	-	-	-	-	-	-	100%	25
2	ТаБГ	4	3	-	-	-	-	-	1	100%	25
3	НБББГ	10	10	-	-	-	-	-	-	100%	25
4	СБГ	29	21	-	2	-	-	1	5	93.3%	23.3
5	ХСХОГ	31	30	-	-	-	-	-	1	100%	25
6	СТСГ	2	2	-	-	-	-	-	-	100%	25
7	ТЗУГ	44	44	-	-	-	-	-	-	100%	25
8	ТСГ	32	32	-	-	-	-	-	-	100%	25
9	СХЭУГ	22	15	-	-	-	-	-	7	100%	25
10	ХЭЗГ	14	12	-	-	-	-	-	2	100%	25
НИЙТ		202	183	-	2	-	-	1	16	99.3%	24.8

Сангийн яам 2024 оны 10 дугаар сард нийт 202 ажил төлөвлөснөөс хэрэгжилт яамны дунджаар **99.3** хувьтай байна. Сарын төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээр ТБТГ, ТаБГ, НБББГ, ХСХОГ, СТСГ, ТЗУГ, ТСГ, СХЭУГ, ХЭЗГ тус бүр 100 хувиар тэргүүлж байна.

СБГ-ын 1 ажил 0 хувийн хэрэгжилт хангалтгүй, 2 ажил 70 хувийн хэрэгжилтийн шатанд байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээнд хамруулаагүй 16 ажил байгаа ба үүнд яам, газрын удирдлагын шийдвэр, бусад байгууллагын үйл ажиллагаанаас хамааралтайгаар цуцлагдсан, хойшлогдсон, асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирээгүй зэрэг шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон ажлууд багтаж байна.

/Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/



Албан бичгийн шийдвэрлэлт (10 сар)

97.6
хувь

Сангийн яаманд 2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт 2768 албан бичиг ирснээс 2186 бичгийн хариуг хугацаанд нь өгсөн хугацаа хоцорч боловсруулж байгаа 19, хугацаа хоцорч боловсруулж дууссан 23 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт **97.6% хувьтай** байлаа. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/.

№	Газар	Боловс- руулж байгаа	Боловс- руулсан	Боловсруулж байгаа /хоцорсон/	Боловсруулсан/х оцорсон/	Нийт	Хувь	Оноо
1	ТБТГ	37	120	8	3	168	91.6%	9.2
2	ТаБГ	10	86	1	2	99	96.6%	9.7
3	НБББГ	13	27			40	100.0%	10.0
4	СБГ	27	200	2	4	233	97.1%	9.7
5	ХСХОГ	170	671	2	8	851	98.5%	9.9
6	СТСГ	4	4			8	100.0%	10.0
7	ТЗУГ	16	82	2	4	104	93.2%	9.3
8	ТСГ	187	657	4	1	849	99.2%	9.9
9	СХЭУГ	3	66			69	100.0%	10.0
10	ХЭЗГ	73	273		1	347	99.6%	10.0
	НИЙТ	540	2186	19	23	2768	97.6%	9.8

Яамны 2024 оны 10 дугаар сарын 07, 14, 21, 28 -ны өдрүүдийн шуурхай хуралдаанаар ТНБД нийт 9 үүрэг даалгаврыг яамны газруудад өгсөн бөгөөд хэрэгжилтийн явц 2024 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 100.0 хувьтай байв. /Шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хавсралт 4-өөс үзнэ үү/.

№	Хариуцсан газар	Шуурхай үүрэг даалгаврын тоо /давхардсан тоогоор/	Үнэлгээний дундаж	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	5	100.0%	5.0	5.0
2	ТаБГ	1	100.0%	5.0	5.0
3	НБББГ	-	-	-	-
4	СБГ	-	--	--	--
5	ХСХОГ	-	-	-	-
6	СТСГ	-	--	--	--
7	ТЗУГ	6	100.0%	5.0	5.0
8	ТСГ	-	-	-	-
9	СХЭУГ	-	-	-	-
10	ХЭЗГ	-	-	-	-
НИЙТ			100.0%	100.0%	5.0



Ажлын цаг ашиглалт (10 сар)

96.6
хувь

Яамны цаг бүртгэлийн системээс авсан мэдээллээр яамны ажлын цаг ашиглалт 2024 оны 10 дугаар сарын байдлаар дунджаар **96.6 хувьтай** байна.

№	Дотоод бүтцийн нэгж	Ажлын цаг ашиглалтын хувь	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	94.12%	10.0	9.4
2	ТаБГ	99.72%	10.0	10.0
3	НБББГ	99.21%	10.0	9.9
4	СБГ	99.58%	10.0	10.0
5	ХСХОГ	96.56%	10.0	9.7
6	СТСГ	97.48%	10.0	9.7
7	ТЗУГ	96.24%	10.0	9.6
8	ТСГ	90.69%	10.0	9.1
9	СХЭУГ	96.62%	10.0	9.7
10	ХЭЗГ	95.68%	10.0	9.6
НИЙТ		96.59%	10.0	9.7

Мөн 2024 оны 10 дугаар сард **200 минутаас дээш хоцролттой** яамны 7 газрын нийт 14 албан хаагчид байна. Үүнд:

- СТСГ-ын З.Анар (3 сар дараалан 200 мин хоцорсон)
- ХСХОГ-ын Н.Сансармаа (2 сар дараалан 200 мин хоцорсон)
- ХЭЗГ-ын Б.Зоригтбаатар
- ТСГ-ын Ч.Цэдэндорж (4 сар дараалан 200 мин хоцорсон), Б.Цагаанцэцэг, Ц.Дагвадорж



Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (10 сар)

100.0
хувь

Яамны холбогдох газрууд яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, үйлчилгээ, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, сангийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, шинэчлэн ажилласан байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар хэрэгжилт **100 хувьтай** байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

№	Цахим хуудсанд мэдээлэл оруулсан газрууд	Үнэлгээ	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	100.0%	10.0	10.0
2	ТаБГ	100.0%	10.0	10.0
3	НБББГ	100.0%	10.0	10.0
4	СБГ	100.0%	10.0	10.0
5	ХСХОГ	100.0%	10.0	10.0
6	СТСГ	100.0%	10.0	10.0
7	ТЗУГ	100.0%	10.0	10.0
8	ТСГ	100.0%	10.0	10.0
9	СХЭУГ	100.0%	10.0	10.0
10	ХЭЗГ	100.0%	10.0	10.0
НИЙТ		100.0%	10.0	10.0

Дүгнэлт

1. Яамны 2024 оны 10 дугаар сард нийт төлөвлөсөн 202 ажлаас 99.3 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба харин 0.7 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 3 ажил) байна.
2. Газруудын албан бичиг шийдвэрлэлтийн байдал 97.6 хувьтай байна. 10 дугаар сард хариу өгөх хугацааг хоцроож шийдвэрлэсэн 23, хоцроон боловсруулж буй 19 албан бичиг байна.
3. 2024 оны 10 дугаар сарын яамны газруудын ажлын цаг ашиглалт дунджаар 96.6 хувьтай байна.



Зөвлөмж

1. 2024 оны 10 дугаар сарын төлөвлөгөөнд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилтийн шатанд буюу удаашралтай байгаа ажлуудыг газрууд дараа сарын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж дуусгах;
2. Сарын биелэлтийг тайлагнахдаа хийсэн ажлын үр дүн, ач холбогдлыг бүрэн гүйцэд, товч, тодорхой бичиж, огноо, албан бичгийн дугаар зэрэг баримт мэдээллийг оруулж, шаардлагатай тайлан мэдээллийг хавсаргаж, дараа сарын 5-ны дотор тайлагнаж хэвших;
3. Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж буй эсэхэд газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах, хариу өгсөн, шийдвэрлэсэн тухай мэдээллийг албан бичгийн бүртгэлийн системд тухай бүрд нь оруулж хэвших;
4. Шуурхай үүрэг, даалгаврын биелэлтийг газрууд долоо хоног бүрийн Пүрэв гарагт хяналт-шинжилгээ, үнэлгээний ЛМ цахим системд хугацаанд нь тогтмол тайлагнаж хэвших;
5. Газар, хэлтсийн ажлын цаг ашиглалтыг сайжруулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.
6. Газрын сарын төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж, батлуулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ (10 сар)

№	Газар	Сарын төлөвлөгөө		Албан бичиг шийдвэрлэлт		Ш/Ү даалгаврын биелэлт		Ажлын цаг ашиглалт		Ү/а-ны нээлттэй ил тод байдал		НИЙТ		
		Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Эзлэх хувь
1	ТБТГ	25.0	25	10.0	9.2	5.0	5.0	10.0	9.4	10.0	10.0	60	58.6	97.7
2	ТаБГ	25.0	25	10.0	9.7	5.0	5.0	10.0	10	10.0	10.0	60	59.7	99.5
3	НБББГ	25.0	25	10.0	10	-	-	10.0	9.9	10.0	10.0	55	54.9	99.8
4	СБГ	25.0	23.3	10.0	9.7	-	-	10.0	10	10.0	10.0	55	53	96.4
5	ХСХОГ	25.0	25	10.0	9.9	-	-	10.0	9.7	10.0	10.0	55	54.6	99.3
6	СТСГ	25.0	25	10.0	10	-	-	10.0	9.7	10.0	10.0	55	54.7	99.5
7	ТЗУГ	25.0	25	10.0	9.3	5.0	5.0	10.0	9.6	10.0	10.0	60	58.9	98.2
8	ТСГ	25.0	25	10.0	9.9	-	-	10.0	9.1	10.0	10.0	55	54	98.2
9	СХЭУГ	25.0	25	10.0	10	-	-	10.0	9.7	10.0	10.0	55	54.7	99.5
10	ХЭЗГ	25.0	25	10.0	10	-	-	10.0	9.6	10.0	10.0	55	54.6	99.3
НИЙТ		25.0	24.8	10.0	9.8	5.0	5.0	10.0	9.7	10.0	10.0	565	557.5	98.7%

Хавсралт 2. Сарын төлөвлөгөөнөөс хэрэгжүүлээгүй болон хэрэгжиж дуусаагүй, удаашралтай байгаа нийт 3, үнэлгээнд хамруулаагүй 16 ажил байна. Үүнд:

0 хувийн хэрэгжилттэй 1 ажил:

Санхүүгийн бодлогын газар:

1. Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлж, зөвшөөрлийг авах. (Л.Сонор, Б.Амарбаясгалан)
Тайлбар: Зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

70 хувийн хэрэгжилттэй 2 ажил:

Санхүүгийн бодлогын газар:

1. Засгийн газрын өрийн статистик тоймыг гаргаж улирал бүр Сангийн яамны цахим хуудсанд байршуулах (Д.Хашчулуу, М.Баасандорж, Л.Гантогтох)
Тайлбар: Цахим хуудсанд байршуулахаар ажиллаж байна.
2. Сангийн яамны гадаад хамтын ажиллагааны дотоод журмыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулах (Д.Жавхлант, Т.Энхсаруул, Г.Түвшинбаяр, Э.Мөнхбилэг)
Тайлбар: Батлуулахаар хянуулж байна.

Сарын төлөвлөгөөнд түсгагдсан бөгөөд үнэлгээнд хамрагдаагүй 16 ажил:

Татварын бодлогын газар:

1. ТМЗҮ-ний тухай хуулийн дагуу татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох болон тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг тусгай зөвшөөрлийн (license.mn) цахим системээр хянан үзэж Сангийн сайдын тушаалаар батлуулах (Д.Баасандаш)
Тайлбар: Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлт ирүүлээгүй байна.

Санхүүгийн бодлогын газар:

1. Сангийн сайдын 2023 оны 195 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Мөнгөн хөрөнгийн удирдлагын хорооны удирдамжид тусгагдсан мэдээллийг хариуцах ажилтнуудаар гаргуулан, нэгтгэх (С.Тулга)
Тайлбар: Тухайн сард хуралдаагүй байна
2. ТЕЗ нараас ирүүлсэн Засгийн газрын тусгай санг байгуулах, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих асуудлыг журамлах асуудлаар ирүүлсэн санал, шийдвэрийн төслийг хянаж, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасан дүгнэлтийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулах Н.Хадбаатар)
Тайлбар: Тайлант сард санал ирүүлээгүй байна
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.16 дахь хэсгийг үндэслэн урт хугацаат зээллэг хийхэд зөвшөөрөл авах хүсэлтийг судлан шийдвэрлэх (Д.Хашчулуу, М.Баасандорж)
Тайлбар: Хүсэлт ирүүлээгүй байна

4. "1998 онд байгуулсан" Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг шинэчлэхээр холбогдох яриа хэлэлцээг эхлүүлэх (Э.Мөнхбилэг)

Тайлбар: Төслийг ирүүлээгүй байна

5. Өрийн удирдлагын тухай хуулийн 16.2, 17.1, 18.1-д заасны дагуу шинээр зээллэг хийх, өрийн зохицуулалтын аливаа үйл ажиллагаа нь Өрийн удирдлагын стратегийн баримт бичиг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хязгаар, Тухайн жилийн зээллэгийн дээд хэмжээнд нийцэж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргах (Д.Хашчулуу, М.Баасандорж)

Тайлбар: Шинээр өр үүсээгүй байна

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар:

1. Төлөвлөгөөт бус дотоод аудит (Б.Гантулга, Х.Түмэнбаяр)
2. Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. (Д.Баатар, О.Энхжаргал, Б.Энхтуяа, С.Баттөр, Д.Энхжин, Н.Билгүүн)

Тайлбар: 2024 оны 10 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас санхүүгийн хяналт, шалгалтын талаар өргөдөл, гомдол ирээгүй болно.

3. Төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэж, үр дүн, тайланг удирдлагад танилцуулах.(Д.Баатар, О.Энхжаргал, Б.Энхтуяа, С.Баттөр, Д.Энхжин, Н.Билгүүн)

Тайлбар:Төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт, шалгалт хийгээгүй байна.

4. Яамны газруудын эрсдэлийг тодорхойлох, Эрсдэлийн хорооны хурлаар хэлэлцэх материалыг бэлтгэж, хорооны хурлыг зохион байгуулах(Б.Гантулга)

Тайлбар: Тус ажил хойшлогдсон байна.

5. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулан, ЭЗХЯ-д хүргүүлэх. (Э.Солонго)

Тайлбар: ЭЗХЯ-аас тайлан ирүүлэх талаар мэдэгдээгүй байна.

6. Ерөнхий сайдын өгсөн шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг яамны холбогдох газруудаас хүлээн авч, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг ЗГХЭГ-ын цахим системд байршуулах (Б.Золбаатар)

Тайлбар: Ерөнхий сайдын өгсөн шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжилтийг авахаар ЗГХЭГ-аас хандаагүй байна.

7. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэх, Засгийн газрын цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний системд оруулан тайлагнах.

Тайлбар: ЗГХХГ-аас тайлан ирүүлэх талаар мэдэгдээгүй байна.

Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар:

1. Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газарт агаараас аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийн хоёрдугаар үе шатны хэрэгжилтийг хангах. (Э.Дөлгөөн)

Тайлбар: 10 дугаар сард СЯ-нд санхүүжилт шийдвэрлүүлэх тухай бичиг ирээгүй байна.

Хууль, эрх зүйн газар:

1. Ажил гүйцэтгүүлэх тендерийн ашиглалтын хугацааны өртөг тооцох аргачлал, заавар боловсруулж, Сангийн сайдын тушаалаар батлуулах (Ч.Баярмаа, Д.Гантулга)

Тайлбар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байгаатай холбогдуулан хойшилсон.

2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг харгалзан баримтлах удирдамжийг боловсруулах (Л.Амгалан, Д.Гантулга)

Тайлбар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байгаатай холбогдуулан хойшилсон.

Хавсралт 3. Хугацаа хоцорч боловсруулж байгаа болон хугацаа хоцорч боловсруулж дууссан албан бичгийн жагсаалт (10 сар)

3.1.Хугацаа хоцорч боловсруулсан албан бичиг

№	Хаанаас	Албан бичгийн дугаар	Албан бичгийн ирсэн огноо	Албан бичгийн дуусах хугацаа	Албан бичгийг хаасан хугацаа	Цохогдсон газар	Мэргэжилтэн
1	Бүгд найрамдах Казахстан улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам	30-182	10/3/2024	10/16/2024	2024-10-21	СБГ	Э.Мөнхбилэг
2	Онцгой байдлын ерөнхий газар Ариунбуян Г	1/2170	10/8/2024	10/21/2024	2024-10-28	СБГ	Б.Анусэцэн
3	Тээвэр хөгжлийн банк Эрдэнэбаяр Б	01/2-721	10/4/2024	10/17/2024	2024-10-29	СБГ	М.Мөнх-Эрдэнэ
4	Эрчим хүчний яам Тавинбэх Н	в/3118	10/7/2024	10/20/2024	2024-10-28	СБГ	Н.Хадбаатар
5	Аж үйлдвэр эрдэс баялгийн сайд Туваан Ц	01/572	10/1/2024	10/14/2024	2024-10-24	ТаБГ	Н.Эрдэнэ
6	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр Ж	01/3084	10/1/2024	10/14/2024	2024-10-18	ТаБГ	Т.Анхбаяр
7	Засгийн газрын хэрэг эрхлэх газар Учрал Н	ХЭГ/1945	10/10/2024	10/23/2024	2024-10-27	ТБТГ	Х.Бадраа
8	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Сарангэрэл А	2/2107	10/10/2024	10/23/2024	2024-10-29	ТБТГ	Э.Цолмон
9	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо Нарантуяа Ч	1/245	10/3/2024	10/23/2024	2024-10-29	ТБТГ	Ж.Алтантуяа
10	20 минутын хот үндэсний хороо Эрдэнэбүрэн Р	01/157	10/2/2024	10/15/2024	2024-10-24	ТЗУГ	З.Баянмөнх
11	Смарт пэймэнт ХХК Энхцог Д	24/18	10/3/2024	10/16/2024	2024-10-20	ТЗУГ	Э.Энхчимэг
12	Татварын ерөнхий газар Чимидсүрэн Ч	01/2203	10/7/2024	10/27/2024	2024-10-30	ТЗУГ	М.Уранчимэг
13	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгж Мөндөр Э	03/113	10/1/2024	10/21/2024	2024-10-30	ТЗУГ	А.Энхтуул
14	Боловсролын яам Батжаргал Х	2/1436	10/10/2024	10/23/2024	2024-10-27	ТСГ	О.Жавхлан
15	Говьсүмбэр аймгийн засаг дарга Батсуурь Г	А/961	10/3/2024	10/16/2024	2024-10-22	ХСХОГ	А.Ундрах
16	Засгийн газрын хэрэг эрхлэх газар Солонгоо Б	ХЭГ/1942	10/10/2024	10/23/2024	2024-10-27	ХСХОГ	Д.Хашчулуу
17	О.Батжаргал, Дорноговь аймгийн засаг даргын тамгын газар	01/1348	10/7/2024	10/21/2024	2024-10-27	ХСХОГ	Т.Хонгор

18	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам Жамбалцэрэн Т	01/3157	10/2/2024	10/15/2024	2024-10-20	ХСХОГ	Г.Өлзийжаргал
19	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам Жамбалцэрэн Т	02/3210	10/10/2024	10/23/2024	2024-10-31	ХСХОГ	Г.Өлзийжаргал
20	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Жамбалцэрэн Т	01/3137	10/2/2024	10/15/2024	2024-10-20	ХСХОГ	Г.Өлзийжаргал
21	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Жамбалцэрэн Т	01/3162	10/2/2024	10/15/2024	2024-10-20	ХСХОГ	Г.Өлзийжаргал
22	Эрүүл мэндийн яам Очирбат Д	2/4033	10/3/2024	10/16/2024	2024-10-20	ХСХОГ	Г.Өлзийжаргал
23	Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх Доржнамжин З	102/АБ2024/04684	10/2/2024	10/15/2024	2024-10-22	ХЭЗГ	Б.Цолмонтуяа

3.2 Хугацаа хоцроон боловсруулж байгаа албан бичгийн жагсаалт

№	Хаанаас	Албан бичгийн дугаар	Албан бичгийн ирсэн огноо	Дуусах хугацаа	Цохогдсон газар	Мэргэжилтэн
1	Үндэсний давхар даатгал ХК Жавхлант Б	01/320	10/16/2024	10/29/2024	СБГ	Ш.Бат-Эрдэнэ
2	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК Энхсайхан М	01/1264	10/3/2024	10/16/2024	СБГ	Ш.Бат-Эрдэнэ
3	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг Болормаа Ц	02/118	10/10/2024	10/23/2024	ТаБГ	Б.Энхбат
4	Аж үйлдвэр эрдэс баялгийн сайд Туваан Ц	01/571	10/1/2024	10/14/2024	ТБТГ	Б.Очиртогтох
5	Боловсролын сайд Наранбаяр П	1/1502	10/14/2024	10/27/2024	ТБТГ	Б.Очиртогтох
6	Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан Л	01/820	10/10/2024	10/23/2024	ТБТГ	В.Содномдаржаа
7	Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан Л	01/783	10/8/2024	10/21/2024	ТБТГ	В.Содномдаржаа
8	Монгол улсын засгийн газар Амарсайхан С	ЗГ-2/716	10/4/2024	10/17/2024	ТБТГ	Б.Дэнсмаа
9	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо Нарантуяа Ч	1/414	10/3/2024	10/30/2024	ТБТГ	Ж.Алтантуяа

10	Үндэсний аудитын газар Энхболд Д	08/1974	10/14/2024	10/27/2024	ТБТГ	В.Содномдаржаа
11	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр Ж	01/3242	10/8/2024	10/21/2024	ТБТГ	Э.Номин-Эрдэнэ; Д.Отгонжаргал
12	Татварын ерөнхий газар Нэргүй Л	03/2166	10/2/2024	10/22/2024	ТЗУГ	А.Энхтуул
13	Татварын ерөнхий газар Чимидсүрэн Ч	01/2183	10/3/2024	10/30/2024	ТЗУГ	Б.Болормаа
14	EDOC.MN, Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар	05-03/5612	10/1/2024	10/29/2024	ТСГ	Ц.Дагвадорж
15	EDOC.MN, Хүүхдийн клиник сувилал дөч	86	10/2/2024	10/31/2024	ТСГ	С.Анхзаяа
16	Шинжлэх ухааны академи Баярбаатар А	4/350	10/15/2024	10/28/2024	ТСГ	Ц.Дагвадорж
17	Э.Мөнхжаргал, Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар	07/3163	10/15/2024	10/28/2024	ТСГ	Ц.Дагвадорж
18	EDOC.MN, Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар	01/5665	10/3/2024	10/31/2024	ХСХОГ	Н.Сансармаа
19	Улсын их хурлын гишүүн Жудагийн Баярмаа	УИХ-03/4150.	10/16/2024	10/29/2024	ХСХОГ	Т.Хонгор

Хавсралт 4. Шуурхай үүрэг даалгаврын тайлан (10 сар)

№	Үүрэг, даалгавар өгсөн албан тушаалтан	Өгсөн үүрэг, даалгавар	Үүрэг, даалгавар өгсөн огноо	Хариуцах газар	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
1	ТНБД	Энэ 7 хоногт УИХ-ын байнгын хороодын хэлэлцэх асуудалд төсвийн төслийн хэлэлцүүлэг байна уу тодруулах, ач холбогдол өгч, бүрэн оролцох.	2024.10.07	ТБТГ	Энэ 7 хоногт төсвийн төслийн талаар Улсын Их Хурлын чуулган болон байнгын хороодын хуралдаагүй. Цаашид төсвийн төслийг Улсын Их Хурлын чуулган болон байнгын хороодын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэж, анхаарч ажиллаж байна.	100%
2	ТНБД	Энэ 7 хоногт Эдийн засгийн зөвлөл дээр тавих татварын талаарх хэлэлцүүлгийн асуудлыг Тэлмүүн дарга, Чимидсүрэн дарга бусад холбогдох дарга нар хоорондоо сайн ярилцаж тохирох. Татварын орчин, өнөөгийн нөхцөл байдал, авах арга хэмжээ гэх байдлаар сэдвээ тохирох, танилцуулах. Гаалийн ерөнхий газар мөн оролцох	2024.10.07	ТАБГ	Эдийн засгийн бодлогын зөвлөл болон Ерөнхий сайдад танилцуулах татварын албаны танилцуулгыг татварын төрөл болон татварын бүтцийн талаарх олон улсын туршлагыг тусган бэлтгэл ажлыг хангасан. Бэлтгэл ажлын явцын хяналтыг тухай бүр /10.14, 15, 16-ны өдрүүдэд/ хийж, нэмэлт сайжруулалтыг хийсэн. 2024 оны 10 сарын 18-нд яамны удирдлагад танилцуулсан	100%
3	ТНБД	Энэ 4 дэх өдрийн УИХ чуулганы хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг хэлэлцэнэ. Бэлтгэл ажлыг сайн хангах.	2024.10.14	ТБТГ	Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай материалыг бэлтгэж, гишүүдийн асуултад хариулах бэлтгэлийг хангасан.	100%
4	ТНБД	Ажлын цагаас олон цаг минут тасалсан, хоцорсон хүмүүст арга хэмжээ авах. Төрийн албаны нөөцөд зөндөө хүн байна. Хэдэн удаа анхааруулах вэ. Газар, хэлтсийн дарга нар албан хаагчдын цаг ашиглалтад анхаарах. Газар хэлтсийн дарга нар өөрсдөө ажлын цаг ашиглалтдаа анхаарах. Хурал,	2024.10.14	ТЗУГ	Шуурхай хурлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу ТЗУГ-аас 2024 оны 9 дүгээр сарын цаг ашиглалтын мэдээг бүх газрын дарга нарт хүргүүлсэн. Хамгийн олон цагийн хоцролттой ТБТГ, СТСГ, ТСГ-ын дарга нарт дахин мэдээлэл хүргүүлж, хоцорсон албан хаагчдад хариуцлага тооцох талаар газар дотроо хэлэлцэн, ТЗУГ-т холбогдох шийдвэрийг ирүүлэхийг мэдэгдсэн болно.	100%

		уулзалтад орохоор бол заавал урьдчилан мэдэгдэх.				
5	ТНБД	Яаманд хүүхдийн өрөө хийх асуудлыг сайн судлах, хугацааны хувьд хэдий үед хийх болон бусад зохион байгуулалтын асуудлыг сайн судалж шийдвэрлэх..	2024.10.21	ТБТГ	Яамны байранд хүүхдийн өрөө байгуулахаар холбогдох журмын дагуу тендер зарлаж, шалгаруулалт явуулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах ажил хийгдэж байна.	100%
6	ТНБД	Энэ 7 хоногт УИХ-ын байнгын хороо, чуулган дагасан хурлаар төвсийн төсөл хэлэлцэнэ. Бэлтгэл ажлыг сайн хангах, холбогдох дарга нар хуралд цагт нь оролцох. Бусад дарга яаман дээр ирцээ бүрэн хангаж ажиллах, энэ асуудалд Тавинжил дарга анхаарах.	2024.10.21	ТБТГ, ТЗУГ	УИХ-ын байнгын хороо, чуулганаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэх бэлтгэл ажлыг хангаж, Улсын Их Хурлын чуулган болон байнгын хорооны хуралдаанд Сангийн сайдын хэлэх үгийг боловсруулсан.	100%
7	ТНБД	Албан бичгийн шийдвэрлэлт, хугацаанд анхаарах. ЗГХЭГ-аас Сангийн яам албан бичиг хоцроосон гэсэн асуудал гарсан. Яаралтай чухал бичгийг дарга нар Сайдад биечлэн танилцуулж байх	2024.10.28	ТЗУГ	Яамны удирдлагын шуурхай хуралд ТНБД-аас өгсөн чиглэлийн дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын дарга албан бичгийн шийдвэрлэлтэд анхаарах талаар холбогдох газрын дарга нарт болон яамны бичиг хэргийн ажилтанд мэдээлэл хүргэсэн. Мөн 7 хоног бүрийн албан бичгийн шийдвэрлэлт, хугацаа хоцорсон бичгийн жагсаалтын гарган, газрын дарга нарт хүргүүлэн ажиллаж байна.	100%
8	ТНБД	Энэ 7 хоногт Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн хэлэлцүүлэг болно. Бэлтгэл ажлыг хангах, дарга нар идэвхтэй оролцох.	2024.10.28	ТБТГ	Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, гишүүдийн асуусан асуултад хариулт өгч ажиллалаа.	100%
9	ТНБД	Яамны шилэн дансанд мэдээ байршуулахад яам болон харьяа газрууд анхаарах. Сайн нягтлан шалгаж байх.	2024.09.23	ТЗУГ	Яамны шилэн дансанд дахь мэдээллийг хугацаанд нь оруулах, гүйлгээний утга, мөнгөн дүн зэрэгт хяналт тавин ажиллаж байна.	100%
ДУНДАЖ					100.0 %	

Хавсралт 5. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (10 сар)

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хариуцсан газар
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг яамны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд мэдээлэн ажилласан. - 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “S&P” агентлагаас манай улсын 2024 оны зээлжих зэрэглэлийг “B+ зэрэг” болж сайжирсныг мэдэгдлээ. Ийнхүү зээлжих зэрэглэл тогтоогч “Fitch Ratings”, “S&P”, “Moody’s” гэсэн олон улсын агентлагийн хоёр нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “B+зэрэг” “B+тогтвортой”болгон сайжрууллаа. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ нэмэгдсэнээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдын итгэх итгэл сайжирч, шууд хөрөнгө оруулалтын суурь бэхжиж, улмаар зээлжих зэрэглэл дахин өсөх дохио болж байна. https://www.facebook.com/photo/?fbid=846562267667208&set=a.177530921237016 - Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл, НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Төрийн санхүүгийн хөтөлбөр-II”-ийн дэмжлэгээр “ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Сангийн яаманд зохион байгууллаа. https://mof.gov.mn/article/entry/2024-10-18 - Монгол Улсын төсвийн тухай мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар хүргэхээр Сангийн яамнаас “Иргэдийн төсөв” эмхэтгэлийг долоо дах жилдээ бэлтгэн нийтэд хүргэсэн болно. Уг эмхэтгэлээс 2025 оны өргөн барьсан төсвийн бодлого, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн талаар мэдээлэл авах боломжтой. https://mof.gov.mn/article/entry/2025-10-01 - Монгол Улсын Засгийн Газар, Жендэрийн Үндэсний Хороо Монгол Улсын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”-г үндэсний хэмжээнд танилцуулах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулан ажиллах Сангийн яам, түүний харьяа Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвийн албан хаагчдад 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр төлөвлөгөөг танилцууллаа. Тус арга хэмжээнд нийслэл, аймаг, орон нутгийн нийт 350 гаруй албан хаагчид танхимаар болон цахимаар оролцсон. Тус мэдээллийн яамны фейсбүүк цахим хуудсанд байршуулсан. https://www.facebook.com/photo/?fbid=861666662823435&set=pcb.861669052823196 - Яамны зохион байгуулалтын бүтэц, нэгжийн мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулсан.	ТЗУГ
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар	Яамны өргөдөл, гомдол хариуцсан ажилтны холбогдох мэдээлэл, утсыг /267246, 110/ яамны цахим хуудас болон 1 давхрын цахим самбарт байршуулсан. Сангийн яаманд хандан Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан 2024 оны 10 дугаар сард нийт 19 өргөдөл санал хүсэл ирснийг яамны холбогдох газруудад хүргүүлж, 100 хувь шийдвэрлэсэн болно.	ТЗУГ

	байрлуулан тухай бүр шинэчлэх;		
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Сангийн яамны шагналыг олгох талаарх “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 75 тоот тушаалыг яамны цахим хуудсанд нээлттэй байршуулсан.	ТЗУГ
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	- Сангийн яаманд тендер шалгаруулалтад оролцогч нараас 2024 оны 9 дүгээр сард ирүүлсэн 209 гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын А/253 дугаар тушаалаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу хянан шийдвэрлэж, холбогдох хариуг хүргүүлсэн мэдээллийг яамны цахим хуудасны ил тод хэсэгт 2024 оны 10 дүгээр сарын 01-ний өдөр байршуулсан болно. https://mof.gov.mn/article/entry/2024_9 - Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас яамны цахим хуудсанд сар бүрийн үнийн мэдээллийг тогтмол байршуулж байна. https://mof.gov.mn/article/entry/2024-1	ХЭЗГ Бусад газрууд
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ын 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт "Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ." гэж заасны дагуу эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн төсөлд санал авах тухай зарыг яамны цахим сайтад 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан болно. Төсөлтэй танилцаж холбогдох саналаа 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн өмнө Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс, 267648, 267416, nomingerel_d@mof.gov.mn хаягт ирүүлэхийг хүсье. https://mof.gov.mn/article/entry/20240731	
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон Шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг материалаа цахим шуудангаар ирүүлж бүртгүүлэх зарыг яамны цахим хуудсанд 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр нээлттэй байршуулсан болно. https://mof.gov.mn/article/entry/202410010001	
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон	Сангийн яамтай 2018 оноос хойш гэрээ байгуулан ажиллаж байгаа ТББ-ын мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан болно. https://mof.gov.mn/article/accounting/tbb-medeelel	ТЗУГ

	мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;		
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Сангийн яамны цахим хуудас /mof.gov.mn/-ны Ил тод хэсэгт Сангийн яамнаас олгодог дараах зөвшөөрлийн холбогдох мэдээллийг тогтмол мэдээлдэг болно. Үүнд: • Эд мөнгөний хонжворт сугалаа эрхлэх тусгай зөвшөөрөл; • Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; • Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; • Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл • Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл; • Үнэт цаас үйлдвэрлэх тусгай тусгай зөвшөөрөл.	Бүх газрууд
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, өр төлбөр, зээл тусламжтай холбоотой мэдээллийг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн. Үүнд: - Уулзалтын үеэр Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, Засгийн газраас баримталж буй төсөв, санхүүгийн бодлогууд, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон төслүүдийн талаар санал солилцлоо. /2024.10.03/ Сангийн сайд Б.Жавхлан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Дэд тэргүүн Кэнжи Окамура 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авч уулзаж, Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, Засгийн газраас баримталж буй төсөв, мөнгөний бодлогууд, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон төслүүдийн талаар санал солилцлоо. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Дэд тэргүүн Кэнжи Окамура Монгол Улсын Засгийн газар төсөв, мөнгөний бодлогоо зөв чиглүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, өрийн хэмжээ, инфляцыг бууруулж, гадаад валютын нөөцөө тогтмол нэмэгдүүлж буйг сайшаав. - Цаашид ОУВС Монгол Улсын засгийн газраас баримталж буй эдийн засгаа төрөлжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, шинэ инновацыг нэвтрүүлэхэд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв. https://www.facebook.com/photo/?fbid=846290997694335&set=pcb.846291117694323 - Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих “Улсын хөрөнгө оруулалтыг зохистой удирдах замаар болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл”-ийн баримт бичигт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж. Ганбат, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И. Батхүү, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мияаги Кэнсүкэ нар 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр гарын үсэг зурав. Техник хамтын ажиллагааны энэхүү төслийн зорилго нь шинээр батлагдсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн, мөн төрийн болон хувийн хэвшлийн эрсдэлийг тодорхойлон үнэлэх, болзошгүй өр төлбөр үүсэх эрсдэлийг удирдах, төсөв, санхүү, санхүүгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, улсын хөрөнгө оруулалтын удирдлагаар дамжуулан хувийн хэвшлийн оролцоог	СБГ

		дэмжих орчныг бүрдүүлэх бөгөөд 2025 оны 3 дугаар сараас эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ. https://mof.gov.mn/article/entry/20241025001 - Монгол Улсын Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат Европын сэргээн босголт, хөгжлийн банкны /ЕСБХБ/ Ерөнхийлөгч Одиль Рено-Бассотой өнөөдөр /2024.10.08/ уулзаж, Чойр-Сайншанд цахилгаан дамжуулах шугамын төслийн найман сая еврогийн нэмэлт санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа. Чойр-Сайншанд чиглэлийн 220 км 220 кВ цахилгаан дамжуулах шугам сүлжээ, Чойр, Сайншанд дахь дэд станцуудыг барих төсөл нь Монгол Улсын эрчим хүчний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой. https://mof.gov.mn/article/entry/20241008001. - Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат Арабын эдийн засгийн хөгжлийн төлөөх Кувейтийн сангийн Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Валийд Аль-Бахарыг хүлээн авч уулзлаа. Арабын эдийн засгийн хөгжлийн төлөөх Кувейтийн сангийн Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Валийд Аль-Бахар 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсад айлчлал хийж байна. Уулзалтын үеэр Монгол Улс болон Кувейтийн сан хоорондын 30 гаруй жилийн түншлэлийг онцлон тэмдэглэж, “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг 4С шатлалтай болгон өргөтгөх төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг баталгаажуулав. https://www.facebook.com/photo/?fbid=848449884145113&set=pcb.848442097479225 - Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Монгол Улсыг хариуцсан Ажлын хэсэг Монгол Улсад 2024 оны 09 дүгээр сарын 25-аас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд, Дэд тэргүүн Кэнжи Окамура 2024 оны 10 дугаар сарын 03-аас 04-ний өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийлээ. ОУВС-гийн Дэд тэргүүн ноён Кэнжи Окамура айлчлалынхаа төгсгөлд хийсэн мэдэгдэлд “Сүүлийн жилүүдэд гаргасан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг сайшаан Засгийн газраас эдийн засгаа зөв удирдан залж, сүүлийн үеийн хүндрэлүүдийг амжилттай даван гарч томоохон гадаад зээлүүдээ дахин санхүүжүүлж, бууруулах чиглэлээр амжилт гаргасан”-ыг онцлов. ОУВС-гийн зүгээс Монгол Улсыг бодлогын зөвлөмж, техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх санаачилгуудаар дамжуулан үргэлжлүүлэн тууштай дэмжихээ дахин илэрхийлж үр дүнтэй хамтын түншлэлээ үргэлжлүүлэн хөгжүүлэхээ илэрхийлэв. https://www.facebook.com/photo/?fbid=846473971009371&set=a.177530921237016	
10.	Төсвийн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл /сая.төгрөг/	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээнд 3,384.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагч, Аймаг, Нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн нийт 1717 гүйцэтгэл, санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр болон https://publicinvestment.gov.mn/ цахим системээр хүлээн авч, хянан баталгаажуулж 1,339,337.18 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	ХСХОГ
11.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд, эдийн засгийн ангиллаар /хувиар/	2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар Барилга байгууламж 68.7%, Их засвар 2.1%, Тоног төхөөрөмж 12%, ТЭЗҮ 1.4%-аар тус тус ангилан https://publicinvestment.gov.mn/ цахим системд ил тод байршуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960457247471	ХСХОГ
12.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн объектын төрөл /тоо/	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээг объектын төрлөөр ангилж https://publicinvestment.gov.mn/ цахим системд ил тод байршуулсан.	ХСХОГ
Хэсгийн дундаж хувь:			
			100%